

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

5-Р САРЫН 20, 2020

Эдийн засгийн судалгааны алба



Эдийн засгийн өсөлт

2020 оны 1-р улиралд ДНБ-ий хэмжээ 10.7 хувиар агшжээ. Энэ нь 2010 оны зэрэгцүүлэх үнээр 3.1 наяд төгрөг юм. Тус агшилтыг пунктээр задлавал Уул уурхайн салбар -7.6, үйлчилгээний салбар -3.3, Аж үйлдвэрийн салбар +0,6, ХАА-н салбар +0,5 мөн бүтээгдэхүүний цэвэр татвар -1 хувийг эзэлж байна.



Инфляц

Дөрөвдүгээр сард улсын хэмжээнд инфляцийн түвшин 4.7 хувь, Улаанбаатар хотод 5.3 хувь байна. Улс даяар үнэ өсөхөд хүнсний бүлгийн үнэ 7.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 4.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 5.4 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



Хөдөлмөр

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх сараас 1.3 мянган хүнээр (6.5%) өссөн байна. Улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс шинээр бүртгүүлсэн өжилгүй иргэд 10.6 хувиар өсч, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 7.7 мянган хүн шинээр бүртгүүлсний 53.0 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байна



Гадаад худалдаа

2020 оны эхний 4 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл 213 сая ам долларын алдагдалтай гарлаа. Худалдааны нийт эргэлт өмнөх оноос 31 хувиар, экспорт 45.3 хувиар харин импорт 10 хувиар буурсан байна. Экспортын орлого ийнхүү буурахад алтны экспорт 115.6 сая америк доллар, зэсийн баяжмалын экспорт 215.2 сая америк доллар, нүүрсний экспорт 629.0 сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлсөн байна.



Улсын төсөв

Дөрөвдүгээр сарын байдлаар улсын төсвийн тэнцэл 643.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. Үүнд төсвийн орлого 14.5 хувиар буурсан ба үүнд төлбөр хураамжийн орлого 33.2 хувь, онцгой албан татварын орлого 23 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ. Харин төсвийн зардал 475 тэрбум төгрөгөөр буюу 17 хувиар өссөн нь хөрөнгийн зардлын 22 хувийн өсөлт, урсгал зардлын 19 хувийн өсөлт нөлөөлжээ.




Ханш

Сарын эцэст ам.долларын ханш 2789 төгрөгт хүрч өмнөх оноос 5.5 хувиар өсчээ. Ковид-19-оос үүдэн гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оноос 457 сая ам доллароор буурсан, экспортын орлого 45 хувиар буурч, төлбөрийн тэнцэл 350 сая ам долларын алдагдалтай байгаа энэ үед төгрөгийн ханш аажмаар сулрах эрсдэлтэй байна.

	Үзүүлэлт	Нэгж	2019.04	2020.04	YoY
Бодит сектор	ДНБ өсөлт (2020.03)	%	6.2%	-10.7%	-16.9 pp.
	Ажилгүйдлийн түвшин (2019.12)	%	6.6%	8.1%	+1.5 pp.
Мөнгөний бодлого	Инфляц	%	7.0%	4.7%	-2.3 pp.
	Мөнгөний нийлүүлэлт	Их наяд ₮	19.91	20.16	+1%
	Зээлийн үлдэгдэл	Их наяд ₮	17.3	16.9	-2%
	Бодлогын хүү	%	11%	9%	-2 pp.
	Ханш (MNT/USD)	₮	2,631.5	2,789	+6%
Сангийн бодлого	Төсвийн орлого	Тэрбум ₮	3,130	2,680	-14%
	Төсвийн зардал	Тэрбум ₮	2,850	3,320	+16%
	Төсвийн тэнцэл	Тэрбум ₮	290	-643	-322%
Гадаад сектор	Экспорт	Сая \$	2,512	1,374	-45%
	Импорт	Сая \$	1,766	1,586	-10%
	Гадаад худалдааны тэнцэл	Сая \$	746	-213	-129%
	Төлбөрийн тэнцэл (2020.03)	Сая \$	220	-350	-259%
	ГВАН (2020.03)	Сая \$	3,660	4,094	+12%


Эдийн засгийн өсөлт

- Бодит дотоодын нийт бүтээгдэхүүний өмнөх мөн үетэй харьцуулсан өсөлт
- Бодит дотоодын нийт бүтээгдэхүүний улирлын өсөлт /улирлын нөлөөллийг арилгасан/
- Poly. (Бодит дотоодын нийт бүтээгдэхүүний өмнөх мөн үетэй харьцуулсан өсөлт)




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Улсын төсвийн тэнцэл




Инфляци




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Төлбөрийн тэнцэл




Гадаадын шууд хөрөнгө оруулалт

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт /Хуримтлуулсан, Сая ам.доллар/
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт /Тухайн сарын, Сая ам.доллар/




Гадаад валютын нөөц

■ Гадаад валютын нөөц ●●● Poly. (Гадаад валютын нөөц)




Эх сурвалж: Монголбанк

Ам.долларын ханш



Хүү



Эдийн засгийн судалгааны алба:

Шинжээч

Г.Батзориг

МУИС-ийн эдийн засгийн ухааны бакалавр, Турк улсын Сакаръя их сургуулийн эдийн засгийн ухааны мастер

Утас: 90171210

Имэйл: Batzorig_g@golomtbank.com

Шинжээч

Э.Батхорлоо

МУИС-ийн эдийн засаг, статистикийн бакалавр

Утас: 99090533

Имэйл: Batkhorloo@golomtbank.com

Эх сурвалж

1212.mn

mongolbank.mn

Голомт банкны дотоод эх сурвалж

Голомт банкны эдийн засгийн судалгааны алба нь макро эдийн засгийн судалгаа болон таамаглалуудыг дотоод ажилчид, харилцагчид болон олон нийтэд хүргэн ажилладаг. Тус тайланд 2020 оны 3, 4-р сарын тоон мэдээлэл болон зарим тохиолдолд 2019 оны 4-р улирлын тоон мэдээллийг ашигласан болно. Энэхүү судалгаа нь зөвхөн банкны дотоод хэрэгцээнд зориулсан бөгөөд Голомт банкны үзэл баримтлалыг илэрхийлээгүй болно.